

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

202... оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар/.....

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжүүлэх журмыг нэгдүгээр хавсралтаар, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын дундаж нормативыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний норматив, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /хэлтэс/, бүх шатны Засаг дарга нар тус тус мөрдөж ажилсугай.

3. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд шаардагдах зардлыг жил бүр улс, орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний жишиг зардлыг энэхүү журмын дагуу тооцож, санхүүжүүлэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар Н.Баярмаа/, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга /Ж. Ганбат/-д тус тус даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Сангийн сайдын 202... оны сарын-ны
өдрийн/..... тоот хамтарсан
тушаалын 1 дүгээр хавсралт

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журамд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхтэй холбогдох норматив болон санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эрсдэлт нөхцөлд байгаа болон хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхдэд шуурхай тусламжийн түвшний үйлчилгээ, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллагад санхүүжилт олгоно.

1.3. Хүүхэд хамгааллын үйлчилгээг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйл, Төсвийн тухай хуульд нийцүүлэн төсвийн төвлөрүүлэн захирагчаар дамжуулан санхүүжүүлэх ба шаардагдах эх үүсвэрийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

1.4. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журмын дагуу магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагад хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг үзүүлсэн үйлчилгээний төрөл, тоо хэмжээнд тулгуурлан олгоно.

1.5. Хүүхэд хамгааллын үйлчилгээний норматив болон санхүүжилт нь мэдээллийн сан дахь тоон мэдээлэлд тулгуурлана.

1.6. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний үед бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх дундаж хугацаа хорин зургаан долоо хоног, бие махбод болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нөхөн сэргээх дундаж хугацаа долоон долоо хоног, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх дундаж хугацаа хоёр долоо хоног байх ба хүүхдэд хамгааллын үйлчилгээ үргэлжлүүлэн үзүүлэх шаардлагатай тохиолдолд үзүүлсэн үйлчилгээний үр дүн, дүгнэлтэд үндэслэн нэмэлт санхүүжилт олгож болно.

1.7. Хүүхэд хамгааллын үйлчилгээг шуурхай тусламжийн, хамгаалах нөхөн сэргээх, зорилтот урьдчилан сэргийлэх гэсэн гурван түвшинд санхүүжилтийг зардлын нормативын дагуу тооцно.

1.8. Инфляцийн түвшин, холбогдох бусад салбарын нормативын өөрчлөлттэй уялдуулан хүүхэд хамгааллын үйлчилгээний нормативыг тухай бүрд шинэчилнэ.

Хоёр. Хүүхэд хамгааллын үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт

2.1. Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг холбогдох мэдээллийн сан, үйлчилгээний үр дүнд тулгуурлан зардлын нормативаар тооцож харьяалах орон нутгийн байгууллагад сар бүрийн 15-ны өдрийн дотор шилжүүлнэ.

2.2. Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны орон нутгийн байгууллага нь санхүүгийн анхан шатны баримтад үндэслэн зардлын нормативын дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг холбогдох төр, төрийн бус байгууллагад шилжүүлнэ.

2.3. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 04-ны өдрийн дотор Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

2.4. Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага нь хүүхэд хамгааллын үйлчилгээнд олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаас өөр бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.

2.5. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага нь хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн гүйцэтгэлийг нормативын дагуу санхүүгийн анхан шатны баримтаар баталгаажуулна.

2.6. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллага нь зарцуулалтыг санхүүгийн анхан шатны баримт болон үйл ажиллагааны тайлангаар баталгаажуулна.

2.7. Үйлчилгээ, үйл ажиллагааны зардлыг санхүүжилтийн бүртгэлийн маягтад бүртгэж, санхүүгийн анхан шатны баримтыг холбогдох бусад баримтаар баримтжуулах ба жил бүр санхүүгийн хяналт, шалгалтад тайлагнана.

Гурав. Шуурхай тусламжийн түвшний үйлчилгээний санхүүжилт

3.1. Шуурхай тусламжийн түвшний үйлчилгээг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, түүнтэй харилцаа холбоо тогтоох, хүүхдийн эрсдэлийн болон нөхцөл байдлыг үнэлэх гэсэн үе шатуудаар, хамгаалах нөхөн сэргээх түвшний үйлчилгээг хаана үзүүлж байгаагаас үл хамаарч, хүүхэд болон гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлэх, төгсгөх гэсэн үе шатуудаар хүргэхэд шаардлагатай зардлыг нормативын дагуу тооцож олгоно.

3.2. Нэг хүүхдэд шуурхай тусламж үйлчилгээ үзүүлэх нормативын бүрэлдэхүүнд нөхцөл байдлын үнэлгээ хийх маягт, шаардлагатай тохиолдолд кэйс нээх зэрэг бичиг хэргийн зардал, баримтжуулах, холбон зуучлах, хүүхэд хамгааллын үйлчилгээний багц болон тээврийн зардал багтана.

3.3. Тээврийн зардлыг газар зүйн байрлал, алслалтаас хамааран Сангийн сайдын баталсан, хүчин төгөлдөр хэрэгжиж буй томилолтын зардлын хэмжээний зам хоногийн зардалтай дүйцүүлэн тооцно.

3.4. Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн тоо болон эрсдэлийн зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх нормативаар шуурхай тусламж үйлчилгээний санхүүжилт тодорхойлогдоно.

3.5. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12.6 дахь заалтийн дагуу үнэлгээ хийсэн нийгмийн ажилтанд харгалзах санхүүжилтийг үндсэн цалин дээр урамшуулал болгон олгоно.

3.6. Нөхцөл байдлын үнэлгээ хийж буй нийгмийн ажилтан нийгмийн ажилтны хамгаалах хэрэглэлээр хангана.

3.7. Хүүхэд хамгааллын үйлчилгээний багцыг шаардлагатай тохиолдолд нийгмийн ажилтанд олгож болно.

3.8. Хүүхэд хамгааллын үйлчилгээний журамд заасны дагуу Хамтарсан багт санхүүжилтийг олгоно.

Дөрөв. Хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээний санхүүжилт

4.1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээг хүргэхдээ хүүхдийг гэр бүлийнх нь орчинд хамгаалан нөхөн сэргээх, хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалан нөхөн сэргээх гэсэн хоёр хэлбэрийн дагуу санхүүжилтийг зардлын нормативаар тооцно.

4.2. Хүчирхийллийн төрлөөс хамааран хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээний норматив ялгаатай байна.

4.3. Хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээний зардлыг үйлчилгээ авсан хүүхдийн тоо, үзүүлсэн үйлчилгээний үр дүнд үндэслэн холбогдох мэдээллийн санд тулгуурлан олгоно.

4.4. Гэр бүлийн орчинд хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зардлын нормативын бүрэлдэхүүнд хүүхэд, гэр бүлийн гишүүдтэй тулж ажилласан ажилтнууд /кейс менежер, хамтарсан багийн гишүүд, сэтгэл зүйн үйлчилгээ, хууль зүйн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ/-ийн урамшуулал, хүүхдэд хүрч үйлчлэх тээвэр, холбон зуучлах, бичиг хэргийн болон шаардлагатай тохиолдолд хүүхдүүдийг бичиг баримтжуулах зардал багтана.

4.5. Гэр бүлээс тусгаарлагдан хамгааллын үйлчилгээ үзүүлэх зардлын нормативын бүрэлдэхүүнд үйлчилгээ үзүүлэгч ажилтнууд /нийгмийн ажил үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, хууль зүйн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, зохицуулагч, үйлчилгээний ажилтан, харуул хамгаалалт/-ын урамшуулал, хүүхдийг байрлуулах /хоол, хүүхэд хамгааллын үйлчилгээний багц/-ын зардал багтана.

4.6. Урамшууллын зардлыг тооцохдоо ажилласан цагийг нэгтгэж үндсэн цалингийн нэг цагт ногдох нэгжийн өртгөөр тооцож кейс хаасны дараа олгоно.

4.7. Гэр бүлээс тусгаарлан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний хоолны зардлыг Мэдээллийн санд үндэслэн хүүхдийг хэд хоног байрлуулсан үйлчилгээ үзүүлсэн хоногоор тооцож олгоно.

4.8. Гэр бүлээс тусгаарлан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний Хүүхэд хамгааллын багцын зардлыг дунджаар 7 хоногийн зардал гэж тооцно.

4.9. Хүүхэд хамгааллын үйлчилгээний багцад ариун цэврийн болон бага үнэтэй түргэн элэгдэх бараа, материалын зардал багтана.

4.10. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хоолны зардлыг холбогдох журмын дагуу тооцож олгоно.

4.11. Төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаад нас барсан хүүхдийн оршуулгын зардлыг хүүхэд хамгааллын зардлаас санхүүжүүлж болно.¹

¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/188 тоот тушаал

Тав. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээний санхүүжилт

5.1. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээнд хүүхдэд чиглэсэн, эцэг, эх гэр бүлд чиглэсэн, олон нийтэд чиглэсэн, хүүхэд хамгааллын салбарын болон салбар дундын байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажил багтана.

5.2. Урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээний зардлын нормативын бүрэлдэхүүнд сургагч багшийн ажлын хөлс, цайны зардал, сургалтын хэрэглэгдэхүүний зардал болон шаардлагатай тохиолдолд сургагч багшийн томилолтын зардал багтана.

5.3. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээний зардлыг тооцохдоо зорилтот бүлгээс хамаарсан зардлын индексээр суурь зардлыг тооцно.

5.4. Зардлын индексийг тооцохдоо хамрах хүрээг тодорхойлно.

5.5. Хүүхдэд чиглэсэн буюу хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, эрхийг хамгаалах, тэдний хөгжил, оролцоог дэмжих ажил, үйлчилгээний санхүүжилтийг тухайн орон нутгийн хүүхдийн тоонд тулгуурлан тооцно.

5.6. Эцэг эх, гэр бүлд чиглэсэн буюу хүний эрх, жендэр, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохирсон өсгөн хүмүүжүүлэх арга аргачлал, амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлын санхүүжилтийг орон нутгийн өрхийн тоонд тулгуурлан индексээр тооцно.

5.7. Олон нийтэд чиглэсэн буюу хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага, соёлыг бэхжүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг тухайн орон нутгийн хүний тоонд тулгуурлан индексээр тооцно.

5.8. Хүүхэд хамгааллын салбарын болон салбар дундын байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, салбар дундын зохицуулалтын хангах сургалт, нөлөөллийн ажлын зардалд хүүхэд хамгааллын нийгмийн ажилтны тоонд үндэслэнэ.

5.9. Хүүхдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлын төсвөөс зорилтот бүлгийн хүүхдийг зусланд амраах, дугуйланд хамруулах зэрэг хүүхэд хөгжлийн зардалд зарцуулж болно.

Зургаа. Санхүүгийн хяналт шинжилгээ, үнэлгээ

6.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт, зарцуулалтын хэмжээ, түүний хүрэлцээтэй эсхүл илүүдэлтэй байдал, оновчтой зөв зарцуулалт зэрэгт мэдээллийн санд тулгуурлан санхүүжилтийн бүртгэлийн маягт, бүрдүүлсэн баримтад санхүүгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмжийг гаргана.

6.2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн үр дүн, үр нөлөөнд хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгүүлж болно.

Долоо. Хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТӨСӨӨГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын
202... оны сарын-ны өдрийн/..... тоот
хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт ...

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ

Нэг. Шуурхай тусламж үйлчилгээний түвшний зардлын норматив

Хүснэгт 1. Шуурхай тусламж үйлчилгээний түвшний зардлын нормативын
задаргаа, төгрөгөөр

№	Зардлын утга	Мөнгөн дүн
1	Бичиг хэргийн зардал	5,000.0
2	Холбон зуучлах зардал	2,000.0
3	Баримтжуулах зардал	2,500.0
4	Шатахуун/ унааны зардал	20,000.0
5	Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц	14,000.0
Нийт дүн		43,500.0

Хоёр. Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний түвшний зардлын норматив

Хүснэгт 2. Гэр бүлийн орчинд нэг хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ
үзүүлэх өртөг, төгрөгөөр

№	Зардлын зүйл	Мөнгөн дүн
1	Тээврийн зардал	178,800.0
2	Бичиг хэрэг	5,000.0
3	Иргэнийг бичиг баримтжуулах	10,000.0
4	Холбон зуучлах	2,000.0
5	Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц	14,000.0
Нийт дүн		209,800.0

Хүснэгт 3. Нэг хүүхдийг түр хамгаалах байр/ нэг цэгийн үйлчилгээний төвд
байрлуулан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх өртөг, төгрөгөөр

№	Зардлын зүйл	Мөнгөн дүн
1	Хоолны зардал	7,500.0
2	Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц	14,000.0
Нийт дүн		21,500.0

Хүснэгт 4. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний өртөг, төгрөгөөр

№	Зардлын зүйл	Мөнгөн дүн
1	Хоолны зардал ² /хоногт хэрэглэх хүнсний өртгийн дундаж/	6,221.0
2	Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц	14,000.0
Нийт дүн		20,221.0

Гурав. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээний зардлын норматив

Хүснэгт 5. Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлын задаргаа, төгрөгөөр

№	Зардлын утга	Зардлын суурь
1	Сургагч багшийн зардал	40,000
2	Цайны зардал	3,000
3	Сургалтын хэрэглэгдэхүүний зардал	2,500
4	Томилолтын зардал	69,000
Нийт дүн		114,500

² Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 159/А/146 тоот тушаал